



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 8707

Улаанбаатар хот

“Багахангай-2024” өвлийн өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/59 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Багахангай-2024” өвлийн өдөрлөг арга хэмжээг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

2. Арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Тус арга хэмжээнд байгууллагынхаа ажилтан, албан хаагчид, иргэдийг бүрэн хамруулан, оролцоог хангаж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4. Арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны *01* дүгээр сарын *02* ны өдрийн
А.О.Т. дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



“БАГАХАНГАЙ-2024” ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Болормаа	Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга
	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга
	Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Алтанцоож	Соёлын ордны захирал
	Б.Гэрэлмаа	Багахангай Тохижилт ОНӨААТҮГ- ын захирал
	Д.Гантулга	Илч-Орд ОНӨААТҮГ-ын захирал
	Г.Тэмүүлэн	Биеийн тамир, спортын хорооны дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 01 дугаар сарын 02 -ны өдрийн
захирамжийн хоёрдугаар хавсралт



“БАГАХАНГАЙ-2024” ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Нийслэл, Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, өвлийн спортыг сурталчлах, иргэдийн чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэхэд арга хэмжээний зорилго оршино.

ХОЁР. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА

Өдөрлөгийн үйл ажиллагааг Багахангай дүүргийн Биеийн тамир спортын хороо, Цагдаагийн хэлтэс хамтран зохион байгуулна. Арга хэмжээ 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 1 дүгээр хорооны “Үнэгтэй гэр хорооллын ар дэнж” дээр зохион байгуулагдана.

Нээлтийн арга хэмжээ: 11.00 цагт эхэлнэ

ГУРАВ. ОРОЛЦОХ БАЙГУУЛЛАГА, ХҮМҮҮС

“Багахангай-2024” өвлийн өдөрлөг арга хэмжээнд Дүүргийн ААНБ-ын ажилтан албан хаагчид, 1,2 дугаар хорооны иргэд оролцоно.

Техникийн зөвлөгөөн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 14.00 цагт Биеийн тамир, спортын хороонд болно. Баг тамирчид мэдүүлэгтэй ирсэн байна. (Олс таталтад оролцох тамирчдын биеийн жин үзнэ.)

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТЭМЦЭЭН, УРАЛДААН

1. “Мөсний шагайн харваа”-Баг тус бүр 4 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвхөн эрэгтэй тамирчид оролцоно. (2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 10.00 цагт дүүргийн 1 дүгээр хорооны мөсөн талбайд)
 2. “Мөсний сур харваа”-Баг тус бүр 4 хүний бүрэлдэхүүнтэй (2 эрэгтэй, 2 эмэгтэй)
 3. Олс таталт (нийт жин 640 кг-4 эрэгтэй, 4 эмэгтэй)
 4. “Буухиа” тэмцээн
 - Байгууллага бүр өөрийн спорт хамтлагийн үйл ажиллагааг сурталчлан оролцоно.
 - “Байгууллага, хороод ажилтан албан хаагч, иргэдийн эрүүл мэндийг хариуцна.
 - Үдийн цайг нь эрүүл хүнсээр бэлтгэн оролцоно.
- Жич: Цөөн хүнтэй ААНБ-ууд нэгдэж оролцож болно.

ТАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тэмцээний төрөл тус бүрд эхний 3 байр эзлүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана. Нийлбэр дүнгээр нэгдүгээр байранд шалгарсан байгууллага хамт олныг Цом, Өргөмжлөл, Мөнгөн шагналаар шагнана.